# Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн

# Т О Г Т О О Л

1958 оны 6 дугаар сарын 18-ны өдөр | Дугаар 191 | Улаанбаатар хот

Ломбардыг татан буулгах тухай.

Манай нам, засгийн хайр халамжийн үр дүнд тус орны ний хөдөлмөрчдийн аж амьдралын хэмжээ эрс дээшилж ирсэний ачаар хогшил хөрөнгөө барьцаалуулан, мөнгө авах хэрэгцээ бараг алга болсон ба мөн ажилчин, албан хаагчдын аар саар хэрэгцээнд шаардагдсан мөнгийг зээлдэн туслах зорилготой олон тооны зээлдэн туслах касс ажиллаж бий зэрэг байдлыг харгалзаж, Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх ломбардыг энэ оны 7 дугаар сарын 1-нээр татан буулгасугай.

2. Ломбардыг татан буулгасантай холбогдуулан, түүний үндсэн хөрөнгө, эд хогшлын зүйлийг хотын гүйцэтгэх захиргааны мэдэлд үлдээж, өр авлагын бүх тооцоог дуусгах талаар арга хэмжээ авахыг Хотын гүйцэтгэх захиргаа /н.БАТЖАРГАЛ/-д үүрэг болгосугай.

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлийн дарга — ЦЭДЭНБАЛ

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга — БАЛАРИ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн эрхлэгч /ЛАГВАДОРЖ/

Б.Н.М.А.У. Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газар
ТОГТООЛ АНГИ